



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 05 сарын 29 өдөр

Дугаар A/400

Ховд

Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Аймгийн Онцгой комиссын 2026 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 13 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Баян-Өлгий аймагт малын гоц халдварт шүлхий өвчин гарсантай холбогдуулан Улс хоорондын тээвэр, Улаанбаатар хотоос Баян-Өлгий аймгийн чиглэлийн ачаа болон хүн тээвэр, хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд Ховд аймгаас Баян-Өлгий аймгийн чиглэлд зорчих тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тодорхойгүй хугацаагаар хязгаарласугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газрын дарга (хурандаа Г.Нэргүй), Цагдаагийн газрын дарга (дэд хурандаа Ш.Сүхтулга), Ховд аймгийн Автотээврийн үндэсний төвийн дарга (П.Үлэмжнاران) нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.АМАРСАНАА